



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн
20 тоот Тогтоолын Хавсралт

**ИНВЕСКОР ББСБ-ЫН
ХӨРӨНГӨ ЗАВШИХ, ЗАЛИЛАНГИЙН ЭСРЭГ БОДЛОГО**

IC-46 V-2.0

2022 он

<p><i>Хамрах хүрээ:</i> ИНВЕСКОР ББСБ ХК түүний охин компаниуд</p>	<p><i>Хариуцах эзэн:</i> Инвескор ББСБ-ын Хууль, Эрсдэлийн Удирдлагын Газар</p>
<p><i>Хувийг хадгалах:</i> Төлөөлөн удирдах зөвлөл, Хууль, Эрсдэлийн Удирдлагын Газар</p>	<p><i>Танилцах:</i> ИНВЕСКОР ББСБ ХК болон охин компаниудын нийт ажилтнууд</p>
<p><i>Хүчинтэй хугацаа:</i> 2022 оны 06-р сарын 22-ны өдрөөс эхлэн</p>	<p><i>Хуудасны тоо:</i> 4 хуудас</p>
<p><i>Дараагийн үнэлгээ хийх огноо:</i> 2023 оны 06 сарын 22-ны өдөр</p>	
<p><i>Журмын дугаар:</i> IC-46</p>	<p><i>Хувилбар:</i> V-2.0</p>

Өөрчлөлтийн түүх

#	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1.	V-1.0	2020.09.16	Анх боловсруулсан.
2.	V-2.0	2022.06.22	Компанийн засаглалын кодексын шинэчлэлтэд нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулав.
3.			
4.			
5.			

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	1
2. ХАМРАХ ХҮРЭЭ	1
3. ХӨРӨНГӨ ЗАВШИХ, ЗАЛИЛАНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ	1
4. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	2
5. ХӨРӨНГӨ ЗАВШИХ, ЗАЛИЛАНГ МЭДЭЭЛЭХ, ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	3

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Хөрөнгө завших, залилангийн эсрэг журам нь /цаашид Журам гэх/ нь Инвескор ББСБ ХК болон түүний охин компаниудын /цаашид нийтэд нь “ББСБ” гэх/ нийт ажилтнуудын хөрөнгө завших, залилангийн шинжтэй үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хамгаалалтын бүсүүдийг чиг үүрэг болон тэдгээр үйлдлийг илрүүлэх, мэдээлэх, шалгах, арга хэмжээ авахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Хөрөнгө завших, залилахтай холбоотой үйлдлийг мэдээлэх нь ажилтан бүрийн заавал биелүүлэх үүрэг байх ба ББСБ нь хөрөнгө завших, залилангийн эсрэг үл тэвчих бодлого баримтална.
- 1.3. Хөрөнгө завших, залилахтай холбоотой байж болзошгүй мэдээллийг ББСБ-ын “Шүгэл үлээх журам”-ын дагуу мэдээлж болно.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. Энэхүү журам нь ББСБ-ын ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд, гэрээт ажилтан, зөвлөх, гэрээт агент, гэрээт байгууллага, бэлтгэн нийлүүлэгч болон ББСБ-тай бизнесийн харилцаа үүсгэн хамтран ажиллаж буй бүхий л хуулийн этгээд болон тэдгээрийн ажилтнуудтай холбоотой бизнесийн болон хөдөлмөрийн харилцаан дахь хөрөнгө завших, залилангийн шинжтэй үйлдэлд хамаарна.

3. ХӨРӨНГӨ ЗАВШИХ, ЗАЛИЛАНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 3.1. Хөрөнгө завших, залилангийн үйлдэл нь Монгол улсын хууль тогтоомж болон ББСБ-ын хэмжээнд мөрдөж буй Бизнесийн ёс зүйн дүрэм, Ажилтны ёс зүйн дүрэм болон бусад бодлого журмыг зөрчсөн буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас ББСБ-д нэр хүндийн, санхүүгийн болон эд хөрөнгийн хохирол учруулах, зохиомол нөхцөл байдлыг зориудаар бий болгох, бодит нөхцөл байдлыг нуух, бизнесийн болон хөдөлмөрийн харилцаан дахь итгэлийг урвуулан ашигласан санаатай үйлдлүүдийг ойлгоно. Үүнд:
 - 3.1.1 ББСБ-ын өмчлөлийн аливаа эд хөрөнгө, мэдээллийг хулгайлах, хууль бусаар ашиглах;
 - 3.1.2 ББСБ-ын хэрэгцээнд зориулсан хангамжийн бараа бүтээгдэхүүнийг үр ашиггүй зарцуулах;
 - 3.1.3 Албан үүргийн дагуу хүлээлгэн өгсөн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завших, хувьдаа ашиглах;
 - 3.1.4 Төлбөр тооцоо эсвэл нөхөн олговрын талаар хуурамч нэхэмжлэл үүсгэх;
 - 3.1.5 ББСБ-ын Бизнесийн ёс зүйн дүрмээр хориглосон үйлдэл, эс үйлдэхүй;
 - 3.1.6 Айлган сүрдүүлэх замаар мөнгө авах, нууц мэдээлэл олж авах;

- 3.1.7 Санхүү, нягтлан бодох бүртгэлээс мэдээлэл хасах, хуурамч эсвэл зохиомол бичилт хийх;
 - 3.1.8 Санхүүгийн хуурамч буюу төөрөгдүүлсэн тайлан, мэдээллийг бий болгох / эсхүл тараах;
 - 3.1.9 Үндэслэл нь баримжаагүй байхад хэт их үнэ, төлбөр төлөх;
 - 3.1.10 Хувийн ашиг сонирхлын зорилгоор ББСБ-ын бодлого, журмыг зөрчих;
 - 3.1.11 ББСБ-ын ашиг сонирхолд хохирол учруулах зорилготой санаатай эсвэл хайхрамжгүй үйлдэл хийх.
- 3.2. Хөрөнгө завших, залилангийн үйлдэл нь энэхүү журмын 3-р зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан үйлдлүүдээр хязгаарлагдахгүй бөгөөд холбогдох хууль тогтоомжид зааснаар зохицуулагдана.

4. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 4.1. ББСБ нь хөрөнгө завших болон залилангийн шинжтэй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг үл тэвчинэ.
- 4.2. ББСБ-ын ажилтан бүр хөрөнгө завших, залилангийн үйлдлээс ангид байж Бизнесийн ёс зүйн дүрэм болон Ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллана.
- 4.3. ББСБ-ын ажилтан хөрөнгө завших, залилантай холбоотой аливаа үйлдэл, эс үйлдэхүйг мэдсэн, илрүүлсэн, сэжиглэсэн даруйдаа шууд удирдлага, эсвэл эрсдэл хариуцсан захиралд мэдэгдэх, тайлагнах үүрэгтэй байна.
- 4.4. ББСБ-ын ажилтан завших, залилангийн шинжтэй үйлдлийг мэдээлэхтэй холбоотой харилцааг ББСБ-ын “Шүгэл үлээх бодлого”-оор давхар зохицуулж болно.
- 4.5. **Хамгаалалтын нэгдүгээр бүс** буюу бизнесийн нэгжүүд болон түүнд дэмжлэг үзүүлэгч нэгжүүд нь дараах үүрэгтэй. Үүнд:
 - 4.5.1. Газар, нэгжийн удирдлага нь өөрийн хариуцсан үйл ажиллагаа, процессуудад гарч болох хөрөнгө завших, залилангийн төрлүүдийг мэддэг, анхаарал хандуулдаг байж эдгээр тохиолдлоос зайлсхийх, сэргийлэхийн тул үр дүнтэй хяналтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх үүрэгтэй.
 - 4.5.2. Газар нэгжийн удирдлага нь шударга бус буюу хуурамч үйл ажиллагааг илрүүлэх, мэдээлэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад хууль зөрчсөн этгээдийг илрүүлэх, дотоод хяналт алба, Дотоод аудитын газар, холбогдох бусад хэлтэс, хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллана.
 - 4.5.3. Хөрөнгө завших, залилангийн үйлдэл илэрсэн тохиолдолд газар нэгжийн удирдлагууд нь зохих залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд цаашид энэ төрлийн үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд хяналтыг илүү үр дүнтэй болгох, давхар болон дараалсан хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 4.6. **Хамгаалалтын хоёрдугаар бүс** буюу Эрсдэлийн удирдлагын нэгж нь дараах үүрэгтэй. Үүнд:

- 4.6.1. Хамгаалалтын нэгдүгээр бүсийн хэрэгжүүлж буй хяналтын үр дүнтэй, үр ашигтай байдалд мониторинг хийх, сайжруулахтай холбоотой зөвлөмж, чиглэл өгөх үүрэгтэй.
- 4.6.2. Хөрөнгө завших, залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэхтэй холбоотой сургалт зохион байгуулж мэдээлэл өгөх үүрэгтэй.
- 4.7. **Хамгаалалтын гуравдугаар бүс** буюу Дотоод аудитын газар нь дараах үүрэгтэй. Үүнд:
 - 4.7.1. Хөрөнгө завших, залилангийн үйлдэл болон сэжигтэй тохиолдлын мэдээллийг хүлээн авч анхан шатны дүгнэлтийг гаргах ба үргэлжлүүлэн шалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бие даан шалгалт явуулах, эсвэл холбогдох эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан хянан шалгах ажлын хэсэг байгуулан хяналт шалгалтыг хийх, дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээг авах үүрэгтэй.
 - 4.7.2. Хамгаалалтын нэгдүгээр бүсийн дотоод хяналтын тогтолцоо болон хяналтууд үр дүнтэй хэрэгжиж буй эсэх, хөрөнгө завших залилангийн үйлдэл гарахаас урьдчилан сэргийлж чадаж байгаа эсэхэд хараат бусаар үнэлэлт дүгнэлт өгөх үүрэгтэй.

5. ХӨРӨНГӨ ЗАВШИХ, ЗАЛИЛАНГ МЭДЭЭЛЭХ, ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.1. ББСБ-ын ажилтан бүр хөрөнгө завших, залилангийн шинжтэй үйлдэл болон сэжигтэй тохиолдлын талаар заавал мэдээлэх үүрэгтэй.
- 5.2. Хөрөнгө завших, залилангийн үйлдэл болон сэжигтэй тохиолдлын талаар мэдсэн боловч мэдээлээгүй, нуун дарагдуулсан, уг үйлдлийг таслан зогсоох боломжийг байгууллагад олгоогүй ажилтныг уг үйлдлийг хөхүүлэн дэмжсэн гэж үзэх бөгөөд ББСБ-ын бизнесийн болон ажилтны баримтлах ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн гэж үзэн сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.
- 5.3. Дотоод аудитын газар нь хөрөнгө завших, залилантай холбоотой мэдээллийг хүлээн авсан даруйд анхан шатны хянан шалгах ажиллагааг хийх ба холбогдох нэгжийн удирдлага нь хянан шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 5.4. Дотоод аудитын газрын анхан шатны хянан шалгах ажиллагаагаар хөрөнгө завших, залилангийн шинжтэй үйлдэл биш гэж дүгнэсэн тохиолдолд холбогдох бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 5.5. Анхан шатны хянан шалгах ажиллагаагаар хөрөнгө завших, залилангийн шинжтэй үйлдэл гэж үзсэн тохиолдолд дотоод аудитын газар нь шалгах ажиллагааг үргэлжлүүлэх ба бие даан шалган шийдвэрлэх, эсвэл ажлын хэсэг байгуулан шалгах асуудлыг шийдвэрлэнэ.
- 5.6. Дотоод аудитын газар нь хянан шалгасан ажлын тайланг холбогдох нэгжийн удирдлагуудад танилцуулах бөгөөд хөрөнгө завших, залилангийн үйлдэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулна.

5.7. Гүйцэтгэх удирдлага болон Хүний нөөцийн газар нь дотоод аудитын хяналт шалгалтын дүгнэлтийн дагуу зохих арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлнэ.

--ooOoo--

